



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2021/17/СТА-ТЭЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2021 он</p>	<p>Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 51-261663, Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням Утас: 51-260949, Цахим хаяг: Sambuunyamyia@audit.gov.mn Аудитын менежер: Г.Гүнжидмаа Утас: 51-261885, Цахим хаяг: Gunjidmaag@audit.gov.mn Ахлах аудитор: Р.Цолмон Утас: 51-261628, Цахим хаяг: Tsolmonr@audit.gov.mn Гэрээт аудитор: М.Ганбаатар</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна у

Агуулга

1.	Санал дүгнэлт.....	2
2.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан.....	4
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан.....	4
2.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан.....	5
2.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан.....	6
2.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	7
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3.	Аудитын тайлан.....	12
3.1	Ерөнхий зүйл.....	12
3.2	Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал.....	13
3.4	Материаллаг байдал.....	13
3.5	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд.....	13
3.5.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө.....	13
3.5.2	Авлага.....	14
3.5.4	Урьдчилгаа.....	14
3.5.3	Бараа материал.....	15
3.5.5	Үндсэн хөрөнгө.....	16
3.5.6	Өр төлбөр.....	16
3.5.7	Засгийн газрын хувь оролцоо.....	17
3.6	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	17
3.7	Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8	Аудитын гол асуудал.....	20
3.9	Шилэн дансны мэдээлэл.....	20
3.10	Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
3.11	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.	Аудитын илрүүлэлт.....	22
5.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	23
6.	Төлбөрийн актын жагсаалт.....	26
7.	Албан шаардлагын жагсаалт.....	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СС	Сангийн сайд
ОБГ	Онцгой байдлын газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
УОК	Улсын онцгой комисс
ОК	Онцгой комисс
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

1. САНАЛ ДҮГНЭЛТ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	147,679,879.6	144,476,301.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	813,465.3	2,548,915.8
33	АВЛАГА	12,311,979.0	18,421,615.7
34	УРЬДЧИЛГАА	242,912.4	1,353,049.4
35	БАРАА МАТЕРИАЛ	56,745,743.8	51,654,783.4
36	НӨӨЦИЙН БАРАА	74,168,340.4	70,497,936.9
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	3,397,438.7	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	265,287,963.6	308,008,462.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	265,287,963.6	308,008,462.3
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	226,681,102.3	268,188,098.6
39300	Биет бус хөрөнгө	38,606,861.2	39,820,363.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	412,967,843.2	452,484,763.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,524,312.1	3,429,993.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,524,312.1	3,429,993.7
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0.0	183,814.4
41300	Өглөг	1,392,058.1	2,557,312.2
41400	Урьдчилж орсон орлого	132,254.1	688,867.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	411,443,531.1	449,054,769.7
51	Засгийн газрын хувь оролцоо	411,443,531.1	449,054,769.7
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	121,463,495.8	121,993,167.0
51200	Хуримтлагдсан үр дүн	232,599,961.6	271,709,771.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,380,073.7	55,351,831.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	412,967,843.2	452,484,763.4

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	283,284,637.2	281,961,604.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	121,363,845.9	82,359,000.1
120	Нийтлэг татварын бус орлого	121,363,845.9	82,359,000.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,920,791.3	199,602,604.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	196,091,331.4	233,850,940.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	196,091,331.4	233,850,940.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	175,484,256.8	211,032,982.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	82,413,079.4	96,681,426.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,090,353.6	6,191,614.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,050,713.8	6,976,914.7
2104	Хангамж, бараа материалын зардал	6,474,218.9	8,175,264.8
2105	Нормативт зардал	6,605,292.1	6,942,182.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,729,137.7	17,092,988.7
2107	Томилолт, зочны зардал	3,025,608.6	2,361,804.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,679,767.6	10,323,262.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,416,085.0	56,287,524.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,607,074.6	22,817,958.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	87,193,305.9	48,110,663.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,663.0	153,606.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	15,522,427.2	5,571,929.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	71,675,541.7	42,692,340.6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	178,176,920.0	240,771,717.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,572,106.5	41,796,351.4
120	Нийтлэг татварын бус орлого	15,572,106.5	41,796,351.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	162,604,813.5	198,975,366.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	165,094,923.5	219,351,703.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	165,094,923.5	219,351,703.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	136,217,559.4	195,054,424.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	82,247,502.6	96,292,177.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,077,667.1	6,225,969.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,027,216.4	7,021,868.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,238,920.0	5,815,093.0
2105	Нормативт зардал	5,525,454.5	9,164,374.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,718,676.6	9,938,451.7
2107	Томилолт, зочны зардал	2,572,971.0	2,252,029.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,922,514.6	11,650,113.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,886,636.5	46,694,346.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,877,364.1	24,297,278.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	13,081,996.5	21,420,014.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	15,038,632.5	19,684,564.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,038,632.5	19,684,564.3
2200	Дотоод эх үүсвэрээр	15,038,632.5	19,684,564.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-15,038,632.5	-19,684,564.3
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,956,635.9	1,735,450.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,770,101.3	813,465.3
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	813,465.3	2,548,915.8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	336,293,700.5	336,293,700.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,204,836.6	3,204,836.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	339,498,537.1	339,498,537.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	269,452.3	269,452.3
9	Тайлант үеийн үр дүн	71,675,541.7	71,675,541.7
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	411,443,531.1	411,443,531.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,582,530.6	-3,582,530.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	407,861,000.5	407,861,000.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-2,072,662.6	-2,072,662.6
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	574,091.2	574,091.2
19	Тайлант үеийн үр дүн	42,692,340.6	42,692,340.6
20	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,054,769.7	449,054,769.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	178,658,516,800.00	175,817,078,781.16	2,841,438,018.84	98.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	160,963,474,600.00	158,272,544,260.66	2,690,930,339.34	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	150,786,778,300.00	148,257,221,763.06	2,529,556,536.94	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,481,885,200.00	95,204,201,367.23	1,277,683,832.77	98.7
210101	Үндсэн цалин	64,556,737,000.00	63,331,737,769.51	1,224,999,230.49	98.1
210102	Нэмэгдэл	28,343,162,900.00	28,360,846,324.04	-17,683,424.04	100.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,246,985,400.00	3,271,933,970.40	-24,948,570.40	100.8
210104	Урамшуулал	334,999,900.00	239,683,303.28	95,316,596.72	71.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,612,013,700.00	6,150,789,709.97	461,223,990.03	93.0
210201	Тэтгэврийн даатгал	3,789,567,800.00	3,616,514,650.15	173,053,149.85	95.4
210202	Тэтгэмжийн даатгал	409,046,600.00	355,521,362.43	53,525,237.57	86.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	327,238,100.00	278,953,731.94	48,284,368.06	85.2
210204	Ажилгүйдлийн даатгал	81,808,900.00	73,134,019.39	8,674,880.61	89.4
210205	Эрүүл мэндийн даатгал	2,004,352,300.00	1,826,665,946.06	177,686,353.94	91.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,101,854,700.00	6,745,258,508.34	356,596,191.66	95.0
210301	Гэрэл, цахилгаан	1,516,766,700.00	1,384,377,488.47	132,389,211.53	91.3
210302	Түлш, халаалт	4,046,365,800.00	3,893,901,198.07	152,464,601.93	96.2
210303	Цэвэр, бохир ус	468,690,500.00	403,988,722.06	64,701,777.94	86.2
210304	Байрны түрээс	1,070,031,700.00	1,062,991,099.74	7,040,600.26	99.3
2104	Хангамж, бараа материалын зардал	4,854,462,500.00	4,790,204,542.76	64,257,957.24	98.7
210401	Бичиг хэрэг	617,801,600.00	612,538,375.90	5,263,224.10	99.1
210402	Тээвэр, шатахуун	3,135,354,500.00	3,114,991,880.35	20,362,619.65	99.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	589,574,000.00	574,471,505.71	15,102,494.29	97.4
210404	Ном, хэвлэл	3,666,800.00	3,681,800.00	-15,000.00	100.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэ рэгчдийн устгал, ариутгал	45,047,200.00	40,029,226.00	5,017,974.00	88.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	463,018,400.00	444,491,754.80	18,526,645.20	96.0
2105	Нормативт зардал	8,110,022,500.00	8,073,555,596.61	36,466,903.39	99.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,647,739,600.00	2,632,116,790.81	15,622,809.19	99.4
210502	Хоол, хүнс	2,452,296,500.00	2,434,469,809.80	17,826,690.20	99.3
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,009,986,400.00	3,006,968,996.00	3,017,404.00	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,155,691,400.00	12,045,070,699.84	110,620,700.16	99.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,230,783,900.00	5,216,598,159.20	14,185,740.80	99.7
210602	Тавилга	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,692,856,900.00	2,616,369,313.64	76,487,586.36	97.2
210604	Урсгал засвар	4,224,050,600.00	4,204,103,227.00	19,947,373.00	99.5
2107	Томиллолт, зочны зардал	939,874,200.00	845,310,527.00	94,563,673.00	89.9
210702	Дотоод албан томиллолт	937,759,900.00	843,196,227.00	94,563,673.00	89.9
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,114,300.00	2,114,300.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,613,215,300.00	13,502,322,047.61	110,893,252.39	99.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,653,267,300.00	11,611,874,030.83	41,393,269.17	99.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	88,603,700.00	78,749,524.00	9,854,176.00	88.9

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	959,292,000.00	956,009,134.36	3,282,865.64	99.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,092,500.00	88,817,293.00	20,275,207.00	81.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,619,400.00	25,018,934.00	2,600,466.00	90.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	385,721,100.00	378,324,487.30	7,396,612.70	98.1
210807	Газрын төлбөр	153,220,700.00	134,126,398.12	19,094,301.88	87.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,696,700.00	607,340.00	1,089,360.00	35.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	234,701,900.00	228,794,906.00	5,906,994.00	97.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	917,758,800.00	900,508,763.70	17,250,036.30	98.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	396,274,700.00	384,645,494.00	11,629,206.00	97.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	521,484,100.00	515,863,269.70	5,620,830.30	98.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,176,696,300.00	10,015,322,497.60	161,373,802.40	98.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	343,881,500.00	335,180,597.60	8,700,902.40	97.5
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	343,881,500.00	335,180,597.60	8,700,902.40	97.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,832,814,800.00	9,680,141,900.00	152,672,900.00	98.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	271,787,500.00	270,381,254.00	1,406,246.00	99.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500,000.00	4,475,000.00	25,000.00	99.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,825,291,900.00	8,685,122,214.00	140,169,686.00	98.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	731,235,400.00	720,163,432.00	11,071,968.00	98.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,695,042,200.00	17,544,534,520.50	150,507,679.50	99.1
220001	Барилга байгууламж	9,653,300,000.00	9,504,090,590.50	149,209,409.50	98.5
222001	Тоног төхөөрөмж	612,000,000.00	611,594,500.00	405,500.00	99.9
224001	Стратегийн нөөц хөрөнгө	7,429,742,200.00	7,428,849,430.00	892,770.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	178,658,516,800.00	176,970,170,069.14	1,688,346,730.86	99.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	169,334,552,400.00	165,685,917,615.85	3,648,634,784.15	97.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	169,334,552,400.00	165,685,917,615.85	3,648,634,784.15	97.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,323,964,400.00	11,284,252,453.29	-1,960,288,053.29	121.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,263,464,400.00	11,012,447,924.29	-1,748,983,524.29	118.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,500,000.00	271,804,529.00	-211,304,529.00	449.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	72,519,999.54	-72,519,999.54	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	72,509,421.00	-72,509,421.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	89	89	0	100.0
610001	Төсвийн байгууллага	89	89	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	7735	7370	365	95.3
620001	Удирдах ажилтан	118	116	2	98.3
620002	Гүйцэтгэх ажилтан	6,430	6071	359	94.4
620003	Үйлчлэх ажилтан	1187	1183	4	99.7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	7735	7370	365	95.3
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1972	1806	166	91.6
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4390	4190	200	95.4
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	1371	1372	-1	100.1

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,366,510,777.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,211,304,269.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,648,860,426.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	719,251,315.19
210101	Үндсэн цалин	295,269,196.39
210102	Нэмэгдэл	44,675,890.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,517,000.00
210104	Урамшуулал	374,789,228.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,444,070.10
210201	Тэтгэврийн даатгал	34,337,258.41
210202	Тэтгэмжийн даатгал	26,702.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,362.34
210204	Ажилгүйдлийн даатгал	5,340.58
210205	Эрүүл мэндийн даатгал	53,405.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,471,975.16
210301	Гэрэл, цахилгаан	14,953,337.16
210302	Түлш, халаалт	8,211,574.00
210303	Цэвэр, бохир ус	21,229,384.00
210304	Байрны түрээс	62,077,680.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,045,672,514.00
210401	Бичиг хэрэг	51,777,321.00
210402	Тээвэр, шатахуун	921,184,473.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,346,175.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	59,264,545.00
2105	Нормативт зардал	1,309,019,305.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	734,121,853.00
210502	Хоол, хүнс	515,306,152.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	59,591,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	971,205,254.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	317,218,687.50
210602	Тавилга	73,465,103.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	220,885,281.00
210604	Урсгал засвар	359,636,183.20
2107	Томилолт, зочны зардал	1,243,828,800.00
210701	Гадаад албан томилолт	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,239,243,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,585,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,910,411,749.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,896,765,137.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	228,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,728,352.00
210807	Газрын төлбөр	191,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	499,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,308,555,442.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,289,881,274.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,674,168.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,562,443,843.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,291,471,013.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	59,610,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,116,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,188,744,513.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,270,972,830.16
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	4,147,200.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,016,922,337.16
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	249,903,293.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,155,206,508.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,155,206,508.00
223001	Бусад хөрөнгө	24,639,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,130,567,508.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36,366,510,777.35
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,366,510,777.35
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,488,030,398.96
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,830,850,318.81
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,539,474,456.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,508,155,602.68
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, олон жилийн насжилттай авлагуудыг барагдуулах, харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийг арилгахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Р.Цолмон, гэрээт аудитор М.Ганбаатар нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн ЗГ-2/350 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шадар сайд нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар гамшиг болон аюулаас хамгаалж, шаардлагатай арга хэмжээ авах, шударга өрсөлдөөнийг зохицуулах, салбарын мэргэжлийн хяналтын болон стандарт, хэмжил зүйн асуудлыг зохион байгуулах зэрэг чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг шуурхай зохион байгуулах;
- Стандарт, хэмжил зүйн асуудлыг хэрэгжүүлэх;
- Шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах;
- Салбарын мэргэжлийн хяналтын асуудлыг зохион байгуулах;
- Эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГХЭГ-ын даргын 2020 оны 36 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын шинэчлэн батлан мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 47 дугаар тушаалаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсан байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар тайлант онд Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын албаны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, тус албаны төсвийн захирагчид цалингийн хэмжээг 6 сарын хугацаатай, 20 хүртэл хувиар бууруулах хариуцлага ногдуулах санал гаргасан байна.

Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар харьяа байгууллагуудын 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар хэрэгжилтийг 96.3 хувьтай гэж үнэлсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүн 233,850.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,338.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлтүүд

3.5.1 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 813.5 сая, эцсийн үлдэгдэл 2,548.9 сая төгрөг болж, 1,735.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.5	0.1	-0,4
Банканд байгаа бэлэн мөнгө	813.0	2,548.8	1,735.8
Дүн	813.5	2,548.9	1,735.4
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	811.7	1,808.5	996.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	1.8	740.4	738.6
Дүн	813.5	2,548.9	1,735.4

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 2,548.8 сая төгрөгөөс 684.8 сая төгрөг төрийн сангийн, 1,864.0 сая төгрөг арилжааны банкин дахь харилцах дансны үлдэгдэл байна.

Арилжааны банк дахь харилцах дансанд байгаа нийт 1,864.0 сая төгрөгийн үлдэгдлээс 1,123.6 сая төгрөг нь төсвийн байгууллага /ОБЕГ-1,123.1 сая, Стандарт, хэмжил зүйн газар-0.3 сая, МХЕГ-0.2 сая/, 740.4 сая төгрөг нь төрийн өмчит үйлдвэрийн газар /Давтан сургалт, сургалт, сэргээн заслын төв/-ын үлдэгдэл тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

- Давтан сургалт, сургалт, сэргээн заслын төвийн нийт 1,304.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт арилжааны банк дахь харилцах дансаар хийгдсэн;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нийт 53.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /ОБЕГ аппарат 50.0 сая, Баянгол дүүргийн ОБХ 1.8 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 2.1 сая төгрөг/;
- ОБЕГ-ын аппарат ЗГ-ын холбогдох шийдвэрийг зөрчин 503.8 сая төгрөгийн зориулалт бус зардлыг санхүүжүүлж, зардал гаргасан;
- Татварын цахим төлбөрийн баримтын системд И баримтгүй шилжүүлсэн болон зөрүүтэй тайлагнасан нийт 254.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Давтан сургалт, сургалт сэргээн засал 67.0 сая, Нийслэлийн ОБГ 31.4 сая, Говь-Алтай аймгийн ОБГ 51.7 сая, Сүхбаатар дүүргийн ОБХ 42.5 сая, Баянгол дүүргийн ОБХ 8.6 сая, Баянзүрх дүүргийн ОБХ 5.4 сая, Багануур дүүргийн ОБХ 20.6 сая, Налайх дүүргийн ОБХ 4.0 сая, Сонгино хайрхан дүүргийн ОБХ 23.6 сая төгрөг/;
- Цалин, урамшууллын зардлыг илүү, дутуу тооцсон, түүнтэй холбоотой татварын зардлыг зөрүүтэй олгосон нийт 102.0 сая төгрөгийн зөрчил байна. /Булган аймгийн ОБГ 0.8 сая, Завхан аймгийн ОБГ 26.0 сая, Хэнтий аймгийн ОБГ 31.8 сая, Говь-Алтай аймгийн ОБГ 10.9 сая, Орхон аймгийн ОБГ 0.1 сая, Сэлэнгэ аймгийн ОБГ 2.2 сая, Өмнөговь аймгийн ОБГ 1.7 сая, Дорнод аймгийн ОБГ 1.4 сая, Сүхбаатар аймгийн ОБГ 2.9 сая, Багануур дүүргийн ОБХ 0.2 сая, Чингэлтэй дүүргийн ОБХ 24.0 сая төгрөг/;
- Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба анхан шатны бүрдэл дутуу баримтаар 6.4 сая төгрөгийн ажил гүйлгээг хийсэн, газрын дуудлага худалдааны дэнчингийн үлдэгдэл 14.0 сая төгрөгийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар жижиг мөнгөн санд зөвшөөрөгдсөн хэмжээнээс нийт 10.6 сая төгрөгөөр орлого, зарлагын гүйлгээ хийсэн, 215.6 сая төгрөгийн гүйлгээг И баримтаар баталгаажуулаагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 12,312.0 сая, эцсийн үлдэгдэл 18,421.6 сая төгрөг болж 6,109.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	37.0	32.2	-4.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	89.1	64.6	-24.5
Татаас, санхүүжилтийн авлага	53.8	1,754.4	1,700.6
Бусад авлага	12,132.1	16,570.4	4,438.3
Дүн	12,312.0	18,421.6	6,109.6
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	12,304.6	18,416.0	6,111.4
ТӨҮГ болон ОНӨҮГ	7.4	5.6	-1.8
Дүн	12,312.0	18,421.6	6,109.6

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт авлага 6,109.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Онцгой байдлын ерөнхий газар 6,493.1 сая, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 32.4 сая төгрөгөөр авлага тус тус өссөнөөс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын үлдэгдэл 366.6 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй. /ОБЕГ аппарат 365.5 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 1.1 сая төгрөг/;
- Олон жилийн насжилттай 11.1 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй. /Сэлэнгэ аймгийн ОБГ 10.4 сая, Завхан аймгийн ОБГ 0.7 сая төгрөг/.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 242.9 сая, эцсийн үлдэгдэл 1,353.0 сая төгрөг болж, 1,110.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	231.7	1,308.1	1,076.4
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	11.0	0.0	-11.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.0	44.9	44.9
Цалингийн урьдчилгаа	0.2	0.0	-0.2
Дүн	242.9	1,353.0	1,110.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	242.9	1,351.7	1,108.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	0.0	1.3	1.3
Дүн	242.9	1,353.0	1,110.1

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд ОБЕГ-ын тайлант онд үүссэн 1,301.4 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний төлбөрүүд байна. Тухайлбал:

- ОБЕГ-ын засварын зардалд 76.8 сая,
- Автомашин /шуурхай алба/-ны урьдчилгаа төлбөрт 51.4 сая,
- Тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгалын зардалд 274.4 сая,
- Гэнэтийн ослын даатгалд 69.5 сая,
- Дүрэмт хувцасны үнэнд 614.5 сая,
- Нөөцийн барааны даатгалд 34.8 сая,
- Тэжээлийн урьдчилгаанд 144.6 сая төгрөг тус тус байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 56,745.7 сая, эцсийн үлдэгдэл 51,654.8 сая төгрөг болж, 5,090.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4. Бараа материал дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	35,470.2	27,625.3	-7,844.9
Дуусаагүй үйлдвэрлэл	1,284.7	797.1	-487.6
Бэлэн бүтээгдэхүүн	1,433.5	2,470.7	1,037.2
Хангамжийн материал	18,449.6	20,598.5	2,148.9
Биологийн хөрөнгө	65.0	110.2	45.2
Мал амьтад	42.7	53.0	10.3
Дүн	56,745.7	51,654.8	-5,090.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	56,306.3	50,856.0	-5,450.3
ТӨҮГ болон ОНӨҮГ	439.4	798.8	359.4
Дүн	56,745.7	51,654.8	-5,090.9

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн бараа материал 32,206.5 сая, үнэ төлбөргүй хандиваар өгсөн 8,349.1 сая, балансаас балансад шилжүүлэн авсан 4,743.2 сая, бусад 2,731.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, худалдаж, зарцуулсан 26,064.5 сая, балансаас балансад шилжүүлсэн 22,606.6 сая, бусад 4,449.6 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн нийт 69.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Нийслэлийн ОБГ 13.7 сая, Сонгино хайрхан дүүргийн ОБХ 3.9 сая, Төв аймгийн ОБГ 51.6 сая төгрөг/;
- Хөрөнгийг эдийн засгийн ангиллыг буруу бүртгэсэн, нийт 19.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Сүхбаатар аймгийн ОБГ 16.3 сая, Завхан аймгийн ОБГ 3.6 сая төгрөг/;
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар бараа материалын зарлага гаргасан, шууд зардалд бүртгэсэн нийт 29.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Завхан аймгийн ОБГ 13.6 сая, Говь-Алтай аймгийн ОБГ 0.4 сая, Дорнод аймгийн ОБГ 0.6 сая, Баянгол дүүргийн ОБХ 6.8 сая, Чингэлтэй дүүргийн ОБХ 8.4 сая төгрөг/.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 265,288.0 сая, эцсийн үлдэгдэл 308,008.5 сая төгрөг болж, 42,720.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	226,681.1	268,188.1	41,507.0
Биет бус хөрөнгө	38,606.9	39,820.4	1,213.5
Дүн	265,288.0	308,008.5	42,720.5
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	260,515.3	302,570.1	42,054.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	4,772.7	5,438.4	665.7
Дүн	265,288.0	308,008.5	42,720.5

Эх сурвалж: МУ-ын Шадар сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд худалдан авсан үндсэн хөрөнгө 11,458.4 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 4,381.6 сая төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 44,168.8 сая, бусад 51,622.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, худалдсан болон акталсан 4,209.0 сая төгрөг, балансаас балансад шилжүүлсэн 40,982.0 сая, бусад 10,122.1 сая төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Чингэлтэй дүүргийн Гал унтраах 10 дугаар ангийн 3,235.0 сая төгрөгийн барилга, Аврах гал унтраах ангийн барилга, 2018 оноос баригдаж буй Увс аймгийн Баруунтуруун сумын 567.3 сая төгрөгийн барилгууд байна.

Аудитын илрүүлэлт:

•Худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчсөн, зориулалт бус зардлаас хөрөнгө бэлтгэсэн нийт 81.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Нийслэлийн ОБГ 34.1 сая, Чингэлтэй дүүргийн ОБХ 36.4 сая, Сонгино хайрхан дүүргийн ОБХ 11.0 сая төгрөг/;

•Жилийн эцсийн тооллогын дүн санхүүгийн тайланд бүртгэлтэй хөрөнгийн дүнгээс зөрүүтэй, зарим хөрөнгө биетээр оршин байхгүй, өөр байгууллагын дансанд давхар бүртгэсэн, элэгдлээ нөхсөн үлдэх өртөггүй нийт 879.3 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. /Архангай аймгийн ОБГ 831.4 сая, Сүхбаатар аймгийн ОБГ 9.3 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 38.6 сая төгрөг/;

•ОБЕГ-ын аппарат холбогдох газрын зөвшөөрөлгүй Hyundai Sonata DNB /шуурхай алба/-ны автомашиныг 92.0 сая төгрөгөөр худалдан авсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 1,524.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,430.0 сая төгрөг болж 1,905.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Богино хугацаат өр төлбөр дүн	1,524.3	3,430.0	1,905.7
Богино хугацаат зээлийн өглөг	0.0	183.8	183.8
Өглөг	1,392.0	2,557.3	1,165.3
Урьдчилж орсон орлого	132.3	688.9	556.6
Дүн	1,524.3	3,430.0	1,905.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	1,424.6	2,806.5	1,381.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	99.7	623.5	523.8
Дүн	1,524.3	3,430.0	1,905.7

Эх сурвалж: Монгол Улсын Шадар сайдын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд дараах байгууллагуудын өр төлбөр ихэнх хувийг эзэлж байна. Үүнд:

- ОБЕГ 2,975.4 сая,
- МХЕГ 396.2 сая,

- Алтанбулаг чөлөөт бүс 72.2 сая төгрөг тус тус байна.

Аудитын илрүүлэлт:

- Өглөгийн үлдэгдэл 202.1 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрсэн байна. /ОБЕГ аппарат 201.4 сая, Хан-Уул дүүргийн ОБХ 0.7 сая төгрөг/;
- Стандарт, хэмжил зүйн газар болон харьяа байгууллагууд нийт батлагдсан төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс 54.6 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 411,443.5 сая, эцсийн үлдэгдэл 449,054.8 сая төгрөг болж, 37,611.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7. Нийт засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /ЗГ-ын сан, ОН-ын сан/	121,463.4	121,993.2	529.8
Хуримтлагдсан үр дүн	232,600.0	271,709.8	39,109.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,380.1	55,351.8	-2,028.3
Дүн	411,443.5	449,054.8	37,611.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	406,322.0	442,693.8	36,371.8
ТӨҮГ болон ОНӨҮГ	5,121.5	6,361.0	1,239.5
Дүн	411,443.5	449,054.8	37,611.3

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 449,054.8 сая төгрөг болж 9.0 хувиар өссөн байна.

ЗГ-ын 2019 оны 438 дугаар тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газар, ЗГ-ын 2018 оны 270 дугаар тогтоолоор Үндэсний итгэмжлэлийн төв үүсгэн байгуулагдаж, Шадар сайдын багцад шилжин ирснээр 2,422.6 сая төгрөгөөр засгийн газрын хувь оролцоо данс нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар Төсвийн ерөнхийлөн захирагч тайлант онд 3,850.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 3,830.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №8. Төвлөрүүлэх орлого /сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	3,850.0	3,830.0	-20.0	99.5

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 373,047.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөсөн боловч санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүргүүлсэн төсвийн төслөөс хөрөнгийн зардлыг 141,464.0 сая, урсгал зардлыг 52,925.4 сая, нийт 194,389.4 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 178,658.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 160,963.5 сая төгрөгийг урсгал зардалд, 17,695.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 169,334.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 9,324.0 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 165,685.9 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт 3,648.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 11,012.4 сая төгрөгөөр бүрдүүлж, төлөвлөснөөс 1,749.0 сая төгрөгөөр давсан нь Стандарт, хэмжил зүйн газар 1,063.0 сая, ОБЕГ 674.5 сая, Үндэсний итгэмжлэлийн төв 11.4 сая төгрөгөөр орлогоо давуулан биелүүлснээс шалтгаалжээ.

Туслах үйл ажиллагааны орлого 271.8 сая төгрөгийг бүрдүүлж, төлөвлөснөөс 211.3 сая төгрөгөөр давсан нь ОБЕГ 17.0 сая, Алтанбулаг чөлөөт бүс 98.9 сая, Замын-Үүд чөлөөт бүс 149.2 сая, Цагааннуур чөлөөт бүс 4.5 сая төгрөгөөр тус тус орлого бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 175,817.0 сая төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь урсгал зардлыг 2,690.9 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 150.5 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Үүнд:

Урсгал зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь бараа, ажил үйлчилгээний зардлыг 2,529.6 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 161.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Урсгал зардлын төсвөөс дутуу зарцуулсан 3,416.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 12 төсөл, арга хэмжээнд 17,695.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 17,544.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 271 иргэн, 91 аж ахуйн нэгж байгууллага, 138 төрийн байгууллага, 48 төрийн бус байгууллагаас 7,488.0 сая, Засгийн газрын нөөц сангаас 17,830.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 3,549.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,508.2 сая, нийт 36,376.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс урсгал зардалд 31,194.3 сая, хөрөнгийн зардалд 1,155.2 сая, нийт 32,349.5 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,027.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т “Цар тахлын үед халдварын голомтот болон эрсдэл бүхий нөхцөлд ажиллах байгууллага, ажилтныг шаардлагатай хамгаалалтын хувцас, хэрэгсэл, техник, багаж, тоног төхөөрөмжөөр хангах, мэдээлэл, сургалт, сэтгэл зүйн туслалцаа болон бусад дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөл бүрдүүлэх, эдгээртэй холбоотой зардлыг

шийдвэрлэх” гэж заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тайлант онд нийт 22,441.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт №9. Улсын болон нэмэлт төсвөөс олгосон санхүүжилт /сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр /данс/	Хөрөнгийн эх үүсвэр	Дүн
1	ОБЕГ /төсөв/	Урсгал төсөв	6,970.4
1.1	ОБЕГ /Нэмэлт санхүүжилт/	Засгийн газрын нөөц сан	7,655.2
1.2	ОБЕГ /Нэмэлт санхүүжилт/	Аймгийн Засаг даргын нөөц сан	1,691.1
1.3	ОБЕГ /Нэмэлт санхүүжилт/	Аймгийн Засаг даргын нэмэлт данс	3.5
1.4	ОБЕГ /Нэмэлт санхүүжилт/	Аймгийн Гамшгийн эрсдэлээс хамгаалах сан	82.9
1.5	ОБЕГ /Нэмэлт санхүүжилт/	Иргэдийн тусгаарлагдсан зардал /Дархан/	93.9
	ОБЕГ-ын нийт дүн		16,497.0
